



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 02

№ 01/04 ДЧА 2018/101/АСА - ТШЗ Мандалговь хот

Г Зөрчил арилгуулах тухай Т

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийх явцад төсвийн хөрөнгөөр уралдаан тэмцээн зохион байгуулж, 150,000.00 /нэг зуун тавин мянга/ төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 147-р тогтооны 3.6-д /улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ялангуяа төсвийн нэмэлт орлого, хандив болон туслахийн орлогоор гадаад, дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, урлагийн наадам, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх/ заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн толбор, зорчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрхзүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг бараёдуулах, зөрчлийг ашигуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.7-д /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр ногоотэй гээж үзсэн бусад нохцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Батлагдсан төсвийн хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын дарга С.Болоржаргал, нягтлан бодогч З.Цэдэнрулам нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

АУДИТОР

Ж.УГТАХБАЯР


ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРАЛ

С.БОЛОРЖАРГАЛ

НЯГТЛАН БОДОГЧ

З.ЦЭДЭНРУЛАМ



¹Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлэхгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанд ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.